

“АДУУНЧУЛУУН” ХК

ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

“АДУУНЧУЛУУН” ХК-ИЙН 2020 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Компани 2020 оны эхний хагас жилд 145.5 мян.тн нүүрс олборлох, 260.0 мян.м³ хөрс хуулах, нийт 382.3 мян.м³ уулын цулын ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн.

1. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

2020 оны 2-р улирлын байдлаар нийт 145.5 мян.тн нүүрс олборлож борлуулахаас 130.2 мян.тн нүүрс олборлож, төлөвлөснөөс 15.3 мян.тн-р буурсан гүйцэтгэлтэй гарч байна.

2019 оны мөн үетэй харьцуулбал нүүрс олборлолт биет хэмжээгээр 14.3 мян.тн-р буурсан байна.

Үзүүлэлт	Х/нэгж	2019-II	2020-II		Зөрүү	
			төлөв	гүйц	2019-с	төл-с
Нүүрс борлуулалт	мян.тн	115.9	145.5	130.2	14.3	-15.3
“ДБЭХС” ХК	мян.тн	103.9	122.5	122.5	18.6	0.0
Ахуй	мян.тн	12.0	23.0	7.7	-4.3	-15.3
Хөрс хуулалт	мян.м3	280.4	260.0	196.1	-84.3	-63.9
Уулын цул		377.8	382.3	305.5	-72.3	-76.8

“ДБЭХС” ТӨХК-д 122.5 мян.тн нүүрс нийлүүлэхээс төлөвлөгөөг 100 хувь биелүүлсэн, ахуйн хэрэглэгчдэд 23.0 мян.тн-ыг нийлүүлэхээс 7.7 мян.тн-ыг нийлүүлж, төлөвлөснөөс 15.3 мян.тн-р буурсан.

- Өнгөрсөн оны мөн үед өрсөлдөгч “Найнги” ХХК 1 тонн нүүрсийг 13600 төгрөг буюу манайхаас 1800 төгрөгөөр бага борлуулснаар хэрэглэгчдийг татсан, үнийн нөлөөллөөс ахуйн борлуулалт өнгөрсөн оны мөн үеэс буурсан.

Нүүрсний нийт олборлолтын 94.1%-ийг “ДБЭХС” ХК-д, 5.9%-ийг айл өрх, ААНэгжүүдэд борлуулсан.

2020 оны 5-р сараас хөрс хуулалтын ажил эхэлсэн, төлөвлөгөө ёсоор 260.0 мян.м³ хөрс хуулахаас 196.1 мян. м³ буюу 63.9%-тай хуулсан. Өнгөрсөн оны мөн үеэс 84.3 мян. м³-р буурсан.

- 4, 5 –р сард гарсан хувьцаа эзэмшигчдийн хоорондох маргааны улмаас 5-р сард дөнгөж эхэлсэн хөрс хуулалт болон тухайн сар дахь нүүрс олборлолтын ажил зогссон.

Тайлант хугацаанд уулын цул 305.5 мян.м³, өнгөрсөн оны мөн үеэс 72.3 мян.м³ буюу 19.1%-иар буурсан.

Нүүрсний 710, 720, 730, 740-р түвшингүүдэд уул геологийн нөхцөл муугаас бутарсан, шавартай нүүрс гарч байгаа тул ахуйн хэрэглэгчдэд нийлүүлэх төлөвлөгөөг 33.5%-тай биелүүлсэн. Цаашид ч энэ нөхцөл байдал удаан үргэлжлэх хандлагатай байгаа тул ахуйн нүүрсээ хангахад хүндрэл үүсэж байна.

2. УДИРДЛАГЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

2020 оны бүтэц, орон тоогоор 109 байнгын ажлын байранд 108 ажилтан албан хаагчидтай ажиллаж байна.

Компани нь захиргаа аж ахуй, санхүү төлөвлөлт хангамж борлуулалт гэсэн 2 хэлтэс, уул технологи, уул, автозасвар, цахилгаан сантехник гэсэн 4 хэсэгтэй.

№	Овог нэр	Албан тушаал
1	Ш.Баясгалан	Гүйцэтгэх захирал
2	Н.Болдрагчаа	Ерөнхий инженер
3	Б.Энхбаатар	Ерөнхий нягтлан бодогч
4	Ю.Лутбаатар	ХАБЭА-н инженер
5	Э.Давааням	УТХДарга, маркшейдер
6	Э.Мөнхтөр	Уулын хэсгийн дарга
7	Г.Баярхүү	Автозасварын хэсгийн дарга
8	Б.Баттөр	Цахилгаан сантехникийн хэсгийн дарга

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд

№	Овог нэр	Албан тушаал
1	Б.Шатар	ТУЗ-ийн дарга
2	Б.Батсайхан	ТУЗ-ийн гишүүн
3	Ш.Мягмарсүрэн	ТУЗ-ийн гишүүн
4	Ш.Баясгалан	ТУЗ-ийн гишүүн
5	Ш.Идэр	ТУЗ-ийн гишүүн
6	Ш.Бямбасүрэн	ТУЗ-ийн гишүүн
7	С.Бадарч	ТУЗ-ийн хараат бус гишүүн
8	М.Шинэтогтох	ТУЗ-ийн хараат бус гишүүн
9	Ө.Амаржаргал	ТУЗ-ийн хараат бус гишүүн
10	О.Гангамөрөн	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

3. САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Тайлант хугацаанд нийт 2087.5 сая.төг-ийн орлого орж, 2701.7 сая.төг-ийн зардал гаргаж ажилласан. Өнгөрсөн онтой харьцуулбал орлого 81.0 сая.төг буюу 4.0 %-иар өссөн, харин зардал 909.5 сая.төг буюу 25.2 %-иар буурсан, алдагдал - 614.2 сая төгрөг гарч, өнгөрсөн оны мөн үеэс 990.5 сая.төг-р буурсан байна.

Үзүүлэлт	Х/нэгж	2019-II	2020-II	Харьцуулалт	
				тоо	%-р
Нийт орлого	сая.төг	2,006.5	2,087.5	81.0	4.0
Нийт зардал	сая.төг	3,611.2	2,701.7	-909.5	-25.2
ТТӨ ашиг	сая.төг	-1,604.7	-614.2	990.5	-61.7

Орлого:

Тайлант хугацаанд нийт орлого 2087.5 сая.төг, үүнээс нүүрсний орлого 1651.3 сая.төг, тээврийн орлого 344.7 сая.төг, бусад орлого 91.5 сая.төг. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт орлого 81.0 сая.төг-р өссөн.

Нүүрсний орлого дотор ахуйн хэрэглэгчдэд нийлүүлсэн нүүрсний биет хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 4.3 мян.тн-р, мөнгөн дүнгээр 60.1 сая төгрөгөөр буурсан.

Гол хэрэглэгч болох “ДБЭХС” ТӨХК-д нийлүүлсэн нүүрсний биет хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 18.6 мян.тн-р, мөнгөн дүнгээр 232.0 сая төгрөгөөр өссөн.

Тээврийн орлого өнгөрсөн оны мөн үеэс 52.9 сая төгрөгөөр буурсан. Үүнд тээврийн гэрээт аж ахуйн нэгжүүдийн нүүрсний захиалга буурсан нь гол нөлөө үзүүлж байна.

Орлого	Х/нэгж	2019-II	2020-II	Харьцуулалт	
				тоо	%
Нүүрсний борлуулалт	сая.төг	1,479.4	1,651.3	171.9	11.6
Станц	сая.төг	1,311.5	1,543.5	232.0	17.7
Ахуй	сая.төг	167.9	107.8	- 60.1	- 35.8
Тээврийн орлого	сая.төг	397.6	344.7	- 52.9	- 13.3
Бусад орлого	сая.төг	129.5	91.5	- 38.0	- 29.3
Нийт	сая.төг	2,006.5	2,087.5	81.0	4.0

Бусад орлого өнгөрсөн оны мөн үеэс 38.0 сая төгрөгөөр буурсан.

Үүнд хүүгийн орлогын бууралт гол нөлөө үзүүлсэн. Хүүгийн орлого өнгөрсөн оны мөн үед 96.0 сая төгрөг байсан бол тайлант хугацаанд 35.0 сая төгрөг буюу 61.0 сая төгрөгөөр буурсан.

Цайны газрын орлого өнгөрсөн оны мөн үеэс 2 дахин өссөн, үүнд талоны тарифын нэмэгдэл шууд нөлөөлж байгаа.

ТАА-н орлого өнгөрсөн оны мөн үеэс 4.8 сая төгрөгөөр өссөн.

Зардал:

Тайлант хугацаанд нийт 2701.7 сая.төг-ийн зардал гаргаж ажилласнаас үндсэн үйлдвэрлэлд 2079.0 сая.төг, удирдлагын зардалд 414.6 сая.төг, үйлдвэрлэлийн бус үйл ажиллагаанд 208.1 сая.төг зарцуулсан байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад зардал 909.5 сая төгрөгөөр буурсан. Үүнд үндсэн үйлдвэрлэлийн зардал 717.3 сая, удирдлагын зардал 83.8 сая, үйл ажиллагааны бус зардал 108.4 сая төгрөгөөр тус тус буурсан.

Дараах хүснэгтэд нийт зардлыг төрлөөр нь задалж харуулав.

№	Зардлын үзүүлэлт	Х/нэгж	2019-II	2020-II	Зөрүү	Зардалд эзлэх хувь
1	Түлш	сая.төг	374.4	211.4	-163.0	10.2
2	ШТМатериал	сая.төг	63.1	49.1	-14.0	2.4
3	Бензин	сая.төг	70.0	22.6	-47.4	1.1
4	Сэлбэг	сая.төг	594.4	272.3	-322.1	13.1
5	Урсгал засвар	сая.төг	60.4	39.7	-20.7	1.9
6	Хангамжийн материал	сая.төг	36.8	11.9	-24.9	0.6
7	Барилгын материал	сая.төг	13.9	3.6	-10.3	0.2
8	Газар ашиглалт түрээс	сая.төг	36.8	32.7	-4.1	1.6
9	Үндсэн ба нэмэгдэл цалин	сая.төг	783.2	714.6	-68.6	34.4
10	Нийгмийн даатгалын шимтгэл	сая.төг	117.7	68.5	-49.2	3.3
11	Цахилгаан	сая.төг	137.8	134.7	-3.1	6.5
12	Дулаан	сая.төг	6.9	5.5	-1.4	0.3
13	Байгаль орчин нөхөн сэргээх	сая.төг	22.9	44.5	21.6	2.1
14	Ус	сая.төг	5.1	7.6	2.5	0.4
15	Даатгал	сая.төг	19.3	5.1	-14.2	0.2
16	Тээврийн зардал	сая.төг	0.7	4.9	4.2	0.2
17	Газрын төлбөр	сая.төг	5.0	13.0	8.0	0.6
18	АМНАТөлбөр	сая.төг	37.0	41.3	4.3	2.0
19	Тээврийн хэрэгслийн татвар	сая.төг	2.6	2.9	0.3	0.1
20	Үл хөдлөх хөрөнгийн татвар	сая.төг	16.8	9.7	-7.1	0.5
21	Албан томилолт	сая.төг	5.3	5.0	-0.3	0.2
22	Бичиг хэрэг	сая.төг	1.6	2.0	0.4	0.1
23	Сургалт	сая.төг	8.7	3.4	-5.3	0.2
24	Холбоо	сая.төг	5.5	3.5	-2.0	0.2
25	Хөдөлмөр хамгаалал	сая.төг	45.7	23.8	-21.9	1.1
26	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил	сая.төг	2.2	20.9	18.7	1.0
27	Гэрээт харуул хамгаалалт	сая.төг	41.3	42.7	1.4	2.1
28	Үндсэн хөрөнгийн элэгдэл	сая.төг	251.4	258.6	7.2	12.4
29	Банкны зээлийн хүү	сая.төг	22.4	7.0	-15.4	0.3
30	Бусад зардал	сая.төг	7.4	16.5	9.1	0.8
	Үйл ажиллагааны зардал	сая.төг	2796.3	2079.0	-717.3	100.0
31	Удирдлагын зардал	сая.төг	498.4	414.6	-83.8	
32	Үйл ажиллагааны бус зардал	сая.төг	316.5	208.1	-108.4	
	Бүрэн өөрийн өртөг	сая.төг	3611.2	2701.7	-909.5	


Үндсэн үйлдвэрлэлийн зардал дотор дараах зардлын бууралт өндөр дүн эзэлж байна.

- түлшний зардал 163.0 сая,
- бензин 47.4 сая,

- сэлбэг 322.1 сая,
- цалин 68.6 сая
- НДШ 49.2 сая төгрөгөөр тус тус буурсан.

Үйл ажиллагааны зардал дотор цалин 33%, элэгдэл 15%, сэлбэг 13%, түлш 10%, бусад зардал 29%-ийг тус тус эзэлж байна.

Үүнд цалингийн зардлын эзлэх хувь анхаарал татаж байна.



Түлшний зардал

Түлшний зардлыг хэсгээр задалбал: өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал автозасварын хэсгийн зардал 82.7 сая, уулын хэсэг 32.3 сая, ЦСТ-ийн хэсэг 0.7 сая, бутлуур 20.5 сая, Захиргаа 26.8 сая төгрөгөөр тус тус буурсан.

Хөрс хуулалт өнгөрсөн оны мөн үеэс 84.3 мян.м3-ээр бага байгаа нь автозасвар, уулын хэсгийн түлшний зардал буурахад гол нөлөөлсөн.

Хэсэг	Х/нэгж	2019-II	2020-II	Харьцуулалт	
				тоо	%
Автозасвар	сая.төг	250.9	168.2	- 82.7	67.0
Уул	сая.төг	71.2	38.9	- 32.3	54.6
ЦСТ	сая.төг	0.8	0.1	- 0.7	12.5
Бутлуур	сая.төг	21.9	1.4	- 20.5	6.4
Захиргаа	сая.төг	29.6	2.8	- 26.8	9.5
НИЙТ ДҮН	сая.төг	374.4	211.4	- 163.0	56.5

Харин бутлуур болон захиргааны хэсгийн түлшний үргүй зардлыг 2020 онд танаснаар тус хэсгүүдийн түлшний зардал 91 хувиар буурсан.

Бензиний зардал

Бензиний зардлыг хэсгээр задалбал: өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал автозасварын хэсгийн зардал 3.2 сая, уулын хэсэг 4.2 сая, ЦСТ-ийн хэсэг 0.1 сая, бутлуур 32.1 сая, захиргаа 8.0 сая төгрөгөөр тус тус буурсан.

Тайлант хугацаанд бутлуур болон захиргааны хэсгийн бензиний үргүй зардалд ихээхэн анхаарч, хяналт тавьж ажилласны үр дүнд энэ 2 хэсгээс 40.1 сая төгрөгийн бензиний хэмнэлт гаргасан. Энэ хэмнэлт нь нийт бууралтын 85 хувийг эзэлж байна.

Хэсэг	Х/нэгж	2019-II	2020-II	Харьцуулалт	
				тоо	%
Автозасвар	сая.төг	13.7	10.5	- 3.2	76.6
Уул	сая.төг	5.5	1.3	- 4.2	23.6
ЦСТ	сая.төг	0.1	0.2	0.1	200.0
Бутлуур	сая.төг	36.5	4.4	- 32.1	12.1
Захиргаа	сая.төг	14.2	6.2	- 8.0	43.7
НИЙТ ДҮН	сая.төг	70.0	22.6	- 47.4	32.3

Сэлбэгийн зардал

Сэлбэгийн зардлыг хэсгээр задалбал: өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал автозасварын хэсгийн зардал 108.6 сая, уулын хэсэг 24.1 сая, бутлуур 179.1 сая, захиргаа 11.1 сая төгрөгөөр тус тус буурсан.

Автозасвар болон бутлуурын хэсгийн сэлбэгийн зардлын бууралт нийт бууралтын 89 хувийг эзэлж байна.

Хэсэг	Х/нэгж	2019-II	2020-II	Харьцуулалт	
				тоо	%
Автозасвар	сая.төг	265.0	156.4	- 108.6	59.0
Уул	сая.төг	135.8	111.7	- 24.1	82.3
ЦСТ	сая.төг	0.1	0.9	0.8	900.0
Бутлуур	сая.төг	181.2	2.1	- 179.1	1.2
Захиргаа	сая.төг	12.3	1.2	- 11.1	9.8
НИЙТ ДҮН	сая.төг	594.4	272.3	- 322.1	45.8

Цалингийн зардал

Тайлант хугацаанд нийт цалингийн фонд 982.8 сая төгрөг, үүнээс үндсэн цалин 490.8 сая, нэмэгдэл цалин 492 сая төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 151.4 сая төгрөгөөр буурсан. Энэ бууралтад жилийн үр дүнгийн бууралт сарын үр дүнгийн бууралт 85 хувийг эзэлж байна.

Компани 2020 оны 1-р сараас ажилчдын тарифт цалинг нэмэгдүүлсэн. Энэ нэмэгдэл нь үндсэн цалин 73.5 сая төгрөгөөр нэмэгдсэнээс харагдаж байна.

Харин сарын үр дүн тооцооллын журамд өөрчлөлт оруулснаар өнгөрсөн оны мөн үеэс 52 хувиар буурсан. Мөн жилийн үр дүнгийн цалинг өнгөрсөн оноос бага хувиар өгсөн нь уг үзүүлэлт буурахад нөлөөлсөн.

Цалин ангилал	Х/нэгж	2019-II	2020-II	Зөрүү
Үндсэн	сая.төг	216.3	244.9	28.6
Цагаар цалин	сая.төг	106.2	132.5	26.3

Хийснээрх цалин	сая.төг	85.6	85.9	0.3
их засвар	сая.төг	9.2	27.5	18.3
Дүн		417.3	490.8	73.5
Нэмэгдэл цалин				
Илүү цаг	сая.төг	17.3	9.9	- 7.4
Шөнө цаг	сая.төг	5.2	8.0	2.8
Шагналт цалин	сая.төг	222.4	127.4	- 95.0
Удаан жил	сая.төг	79.5	102.4	22.9
Амралт	сая.төг	168.8	117.5	- 51.3
Сарын үр дүн	сая.төг	185.4	88.5	- 96.9
Бусад	сая.төг	38.3	38.3	-
Дүн	сая.төг	716.9	492.0	- 224.9
<u>Нийт цалингийн фонд</u>	сая.төг	1,134.2	982.8	- 151.4

Цалингийн фондыг хэсэг тус бүрээр задалбал: өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад автозасварын хэсэг 61.1 сая, уулын хэсэг 47.5 сая, ЦСТ хэсэг 3.1 сая, Захиргаа 36.1 сая, ТАА 4.2 сая төгрөгөөр тус тус буурсан.

Дундаж цалин өнгөрсөн оны мөн үед 1.4 сая, тайлант хугацаанд 1.5 сая төгрөг байна.

Нийт ажилчдын тоо өнгөрсөн оны мөн үед 140, тайлант хугацаанд 109 буюу 31 хүнээр буурсан.

Хэсэг	Х/нэгж	2019-II	2020-II	Зөрүү
Автозасварын хэсэг	сая.төг	350.1	289.0	-61.1
Уулын хэсэг	сая.төг	303.1	255.6	-47.5
Цахилгаан сантехникийн хэсэг	сая.төг	130.0	126.9	-3.1
Захиргаа	сая.төг	259.0	222.9	-36.1
Туслах аж ахуй	сая.төг	67.8	63.6	-4.2
Цайны газар	сая.төг	24.2	24.8	0.6
<u>Нийт цалингийн фонд</u>	сая.төг	1134.2	982.8	-151.4
Дундаж цалин	сая.төг	1.4	1.5	0.2

ТУЗ, удирдлагын зардал

ТУЗ-ийн зардал тайлант хугацаанд 74.8 сая төгрөг гарч өнгөрсөн оны мөн үеэс 6.0 сая төгрөгөөр буурсан. Үүнд түлш, бензиний зардлын бууралт нөлөөлсөн.

Удирдлагын зардал тайлант хугацаанд 266.4 сая төгрөг гарч өнгөрсөн оны мөн үеэс 79.7 сая төгрөгөөр буурсан. Үүнд цалингийн бууралт буюу жилийн үр дүнгийн нэмэгдэл өнгөрсөн оноос бага хувиар тооцсон нь нөлөөлсөн.

Хэсгүүд	Хэсгүүд	Х/нэгж	2019-II	2020-II	зөрүү
ТУЗ	Сэлбэг	сая.төг	4.7	0.4	-4.3
	Цалин	сая.төг	54.4	59.9	5.5
	НДШ	сая.төг	7.6	8.2	0.6
	Албан томилолт	сая.төг	2.7	1.3	-1.4

	Бензин, түлш, ШТМ	сая.төг	10.4	3.5	-6.9
	Бусад	сая.төг	1.0	1.5	0.5
	Дүн	сая.төг	80.8	74.8	-6.0
Удирдлага	Сэлбэг	сая.төг	5.7	6.5	0.8
	Цалин	сая.төг	271.2	187.0	-84.2
	НДШ	сая.төг	37.2	26.3	-10.9
	Албан томилолт	сая.төг	5.2	3.1	-2.1
	Бензин, түлш, ШТМ	сая.төг	11.6	25.3	13.7
	Бусад	сая.төг	15.2	18.2	3.0
	Дүн	сая.төг	346.1	266.4	-79.7
НИЙТ ДҮН		сая.төг	426.9	341.2	-85.7

Үйл ажиллагааны бус зардал

Тайлант хугацаанд үйл ажиллагааны бус зардал 208.1 сая төгрөг гарч өнгөрсөн оны мөн үеэс 108.4 сая төгрөгөөр буурсан. Үүнд шагнал урамшууллын зардал 13.8 сая, хандив буцалтгүй тусламж 52.2 сая, бусад зардал 26.2 сая, ТАА-н цалин 25.2 сая төгрөгөөр тус тус буурсан.

№	Зардлын үзүүлэлт	Х/нэгж	2019-II	2020-II	Зөрүү
1	Шагнал урамшуулал	сая.төг	43.0	29.2	-13.8
2	Хандив, буцалтгүй тусламж	сая.төг	76.4	24.2	-52.2
3	Үйл ажиллагааны бус бусад	сая.төг	45.9	18.8	-26.2
4	ТАА цалин	сая.төг	50.4	25.2	-25.2
5	ТАА НДШ	сая.төг	7.3	3.5	-3.8
6	ТАА Засвар үйлчилгээ	сая.төг	4.6	1.8	-2.8
7	ТАА түүхий эд материал	сая.төг	6.6	2.7	-3.9
8	ТАА малын хорогдол	сая.төг	4.2	9.2	5.0
9	ТАА хангамжийн материал	сая.төг	1.3	13.2	11.9
10	ТАА бензин, түлш, ШТМ	сая.төг	6.6	2.2	-4.4
11	ТАА элэгдэл	сая.төг	0.4	0.9	0.5
12	ТАА бусдаар гүйцэтгүүлсэн	сая.төг	1.0	1.6	0.6
13	Гуанз цалин	сая.төг	24.2	24.8	0.6
14	Гуанз НДШ	сая.төг	3.5	3.8	0.3
15	Гуанз засвар үйлчилгээ	сая.төг	0.4	0.1	-0.3
16	Гуанз түүхий эд материал	сая.төг	38.1	44.2	6.1
17	Гуанз хангамжийн материал	сая.төг	1.5	1.9	0.4
18	Гуанз элэгдэл	сая.төг	1.1	0.8	-0.3
	Үйл/а бус зардал	сая.төг	316.5	208.1	-108.4

Үйл ажиллагааны нэгжийн өртөг:

	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2019-II	2020-II	Зөрүү
I	Нүүрс олборлолт	тн	115.9	130.2	14.3
II	Бүрэн өөрийн өртөг	төг	3611.2	2701.7	-909.5
III	1 тн нүүрсний өртөг	төг	31,157.9	20,750.4	-10,407.5

1 тн нүүрсний өртөг 2019 оны 2-р улиралд 31157.9 төгрөг байсан бол тайлант хугацаанд 20750.4 төгрөг болж 10407.5 төгрөгөөр буурсан.

Үр ашиг, алдагдал:

Тайлант хугацаанд үйл ажиллагаанаас нийт 2087.5 сая.төг-ийн орлого олж, 2701.7 сая.төг-ийн зардал гаргаж -614.2 сая.төгрөгийн алдагдалтай гарч байна.

Өнгөрсөн оны мөн үеэс алдагдал 990.5 сая. төгрөгөөр буурсан. Үүнд зардлын бууралт шууд нөлөөлсөн.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад орлого 4.0%-иар өсөж, зардал 25.2%-иар буурсан байна.

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2019-II	2020-II	Харьцуулалт	
				зөрүү	%
Нийт орлого	сая.төг	2,006.5	2,087.5	81.0	4.0
Нийт зардал	сая.төг	3,611.2	2,701.7	-909.5	-25.2
Татвар төлөхийн өмнөх ашиг	сая.төг	-1,604.7	-614.2	990.5	-61.7
Орлогын татварын зардал	сая.төг	0.0	0.0	0.0	0.0
Татварын дараах ашиг	сая.төг	-1,604.7	-614.2	990.5	-61.7

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

НИЙТ ХУВЬЦААНЫ ТОО: 3 151 304

НИЙТ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТОО: 1150

/2020 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар/

Компанийн хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшигчдийн талаарх мэдээлэл

№	Овог нэр	Эзэмшиж буй хувьцаа
1	Б.Шатар	51%
2	“Адуунчулуун” ХК	18%
3	Ц.Шинэбаяр	18%

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2020 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр Дорнод аймаг, Хэрлэн сум, 8-р баг, компанийн өөрийн байранд 14:00 цагт 2 778

899 саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 88,2 хувийн ирцтэйгээр хуралдан дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэв. Үүнд:

1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны тайлан, 2020 оны зорилт
2. Компанийн 2019 оны санхүүгийн тайлан, 2020 оны эдийн засгийн төлөвлөлт
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн тайлан
4. Компанийн 2018 оны ногдол ашгийг хуваарилж тараасан тухай мэдээлэл, 2019 оны ногдол ашгийг хуваарилахгүй талаарх ТУЗ-ийн шийдвэр, ашгийн тухай танилцуулга
5. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ БА ХУВЬЦАА

2020/01-2020/06 хувьцааны ханш, арилжаа



Эх сурвалж: <http://mse.mn/mn/company/461>


ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХУВЬЦААНЫ АРИЛЖААНЫ МЭДЭЭ

№	Ханш				Арилжигдсан		
	Дээд	Доод	Нээлт	Хаалт	Ширхэг	Үнийн дүн	Огноо
1	900	900	900	900	50	45000	20.06.30
2	1020	1020	1020	1020	21921	22359420	20.06.03
3	1030	1030	1030	1030	1	1030	20.05.29
4	1020	1020	1020	1020	82	83640	20.05.26
5	1030	1030	1030	1030	198	203940	20.05.22
6	1030	1030	1030	1030	24	24720	20.04.21
7	1030	1030	1030	1030	13	13390	20.04.14
8	1030	1030	1030	1030	93	95790	20.04.10
9	1032	1030	1032	1031	7	7217	20.03.30
10	1098	1098	1098	1098	9	9882	20.03.26
11	1050	1050	1050	1050	5	5250	20.03.25
12	1032	1032	1032	1032	10	10320	20.03.17
13	1030	1030	1030	1030	15	15450	20.03.13

14	1030	1030	1030	1030	5	5150	20.03.10
15	1020	1020	1020	1020	1	1020	20.03.06
16	1098	1049	1049	1065	3	3196	20.03.04
17	1050	1049	1050	1049	113	118592	20.03.03
18	1050	1050	1050	1050	5	5250	20.03.02
19	1101	1100	1100	1101	241	265130	20.02.20
20	1100	1100	1100	1100	105	115500	20.02.19
21	1220	1220	1220	1220	2	2440	20.02.14
22	1220	1200	1220	1201	21	25220	20.02.13
23	1200	1200	1200	1200	302	362400	20.02.12
24	1350	1300	1300	1314	35	46000	20.02.11
25	1395	1350	1350	1395	51	68895	20.02.06
26	1350	1350	1350	1350	39	52650	20.01.30
27	1350	1350	1350	1350	11	14850	20.01.29
28	1357	1357	1357	1357	80	108560	20.01.24
29	1357	1357	1357	1357	20	27140	20.01.21
30	1357	1357	1357	1357	1050	1424850	20.01.15

Үзүүлэлт		2020.06.30
Хувьцааны төрөл	Энгийн хувьцаа	
Хувьцааны үнэ /төгрөг/	900	
Хаалтын үнэ	900	
Хамгийн их үнэ	1395	
Хамгийн бага үнэ	900	
Дундаж үнэ	1128	
Арилжаалагдсан тоо /ширхэг/	24,512	
Арилжааны үнийн дүн /төгрөг/	25,521,892	

6. НОГДОЛ АШГИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ



Компани 2018 оны үйл ажиллагааны ашгаас 2019 онд нэгж хувьцаанд 130 төгрөг хуваарилах шийдвэр гаргаж нийт 409,7 сая төгрөгийн ногдол ашгийг хуваарилсан. 2019 онд алдагдалтай ажилласан тул ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэв.